



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 11

Чингис хот

Өргөдөл хянан шалгах комисс
байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.3-т заасны дагуу ТОГТООХ нь:

1. Өмнөдэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Баярмаагийн салбар зөвлөлд хандан гаргасан өргөдлийг хянан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Л.Бат-Октябрь	-Салбар зөвлөлийн гишүүн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Болд	-Салбар зөвлөлийн гишүүн, Цагдаагийн газрын дарга
	Б.Баярсайхан	-Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн Тамгын газрын дарга

2. Маргааныг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу 30 хоногийн дотор шударга, шуурхай шалган шийдвэрлэж, дүгнэлт гарган Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комиссын дарга /Л.Бат-Октябрь/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР